

2019

ХАГАС
ЖИЛИЙН
ТАЙЛАН

БидиСЕК ҮЦК ХУВЬЦААТ КОМПАНИ



GRAND BULL AWARDS

2014-2018

ШИЛДЭГ АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИ

“БИ ДИ СЕК ҮЦК” ХК





БидиСЕК ҮЦК ХК

Андеррайтер, Брокер, Хөрөнгө оруулалтын зөвлөх



60,101 Харилцагчийн данс нээгдэв.

5.5 тэрбум төгрөгийн арилжаа хийв.



Онлайнаар арилжааны данс нээдэг болсон.

“Weekly Report”-ыг ТУЗ гишүүн Улуч Бинголтой хамтран гаргадаг болов.

ХЭХ амжилттай зохион байгуулав.

Гадаад арилжаанд оролцогсодын тоо 20%-иар нэмэгдэв.



ТАЙЛАНГИЙН ЭХНИЙ ХЭСЭГ



Үйл ажиллагааны чиглэл:

- Брокер Дилер
- Андеррайтер
- Хөрөнгө Оруулалтын Зөвлөх
- Гадаад Арилжаанд Зуучлах



Хувьцаа эзэмшигчдийн тоо: 517 /2019.03.22/

Эрхэм зорилго:

“ Үндэсний үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн цогц үйлчилгээгээр дэмжих, олон улсын стандартанд нийцсэн санхүүгийн зах зээлд тэргүүлэгч байгууллага болох.”


Манай компани нь:

“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн үйл ажиллагаа Монгол Улсад Хөрөнгийн Зах Зээл үүссэн 1991 оноос эхэлсэн бөгөөд өдгөө 28 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж буй тус салбарын ууган компаниудын нэг юм.

БиДиСЕК ҮЦК нь Монголын Хөрөнгийн зах зээл дээр Андеррайтер, Брокер, Дилер, Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг гадаад дотоодын харилцагчид, түнш байгууллагууддаа цогцоор нь чанарын өндөр түвшинд үзүүлж, урт хугацааны итгэлтэй түншлэлийн харилцааг эрхэмлэн ажиллаж ирсэний үр дүнд дотоодын Хөрөнгийн зах зээлийн тэргүүлэгч компани болж чадсан.

Энэ бүхнийг манай компанийн үйлчилж буй харилцагчидын тоо, үнэт цаасны арилжааны хэмжээ, гаргасан IPO, санхүүгийн чадвар, тогтвортой байдал, харилцагчиддаа үзүүлдэг үйлчилгээний төрөл зэрэг олон үзүүлэлтүүд илтгэдэг.


2018 оны хагас жилийн байдлаар үнэт цаасны зах зээлд оролцох данстай харилцагчдын тоо, нийт зах зээлийн харилцагчдын 25 хувь буюу 250,000 гаруй харилцагчтай үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд 2019 оны эхний хагас жилд 60,101 шинэ харилцагчтай болсон.





а. Брокерийн үйл ажиллагаа:

“БиДиСЕК ҮЦК” ХК нь харилцагч, хөрөнгө оруулагчдад Монголын Хөрөнгийн зах зээл дээрээс үнэт цаас худалдан авах, худалдах захиалгыг зуучлалын үйл ажиллагаа буюу брокерийн үйлчилгээг дамжуулан түргэн шуурхай гүйцэтгэж байна.



- a) Арилжааны танхим
- b) Мэдээлэл, судалгаа
- c) Хөрөнгө оруулагчдын уулзалт
- d) Багцын арилжаа
- e) Онлайн Брокерын үйлчилгээ
- f) Бусад нэмэлт үйлчилгээнүүд



б. Андеррайтерийн үйл ажиллагаа:

Бид андеррайтерийн үйл ажиллагааны хүрээнд санхүүжилт шаардлагатай байгаа компанийн үнэт цаасыг хаалттай болон нээлттэй хүрээнд хөрөнгө оруулагчдад зуучлан борлуулах, зарим тохиолдолд үнэт цаасыг нь анхдагч зах зээл дээрээс бүхлээр нь болон хэсэгчлэн худалдан авах, үнэт цаасны бүртгэлийн болон анхдагч зах зээлийн арилжааг удирдан зохион байгуулан ажилладаг.

- a) Хувьцаагаар санхүүжилт татах
 - 1) Шууд хөрөнгө оруулалт
 - 2) Шинээр хувьцаа гаргах буюу IPO
 - 3) Давуу эрхийн хувьцаа
 - 4) Нэмэлт хувьцаа гаргах буюу FPO
 - 5) Давхар бүртгэл буюу Cross-listing
- b) Зээлийн санхүүжилт
 - 1) Хаалттай бонд
 - 2) Нээлттэй бонд
 - 3) Хөрвөх зээл
 - 4) Хөрвөх бонд

с. Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ:

Манай компани 2007 онд “Санхүүгийн Зохицуулах Хороо”-ноос Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх эрхийг авсанаар үнэт цаасанд хөрөнгө оруулах сонирхолтой хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагад хөрөнгө оруулалт хийхэд нь зөвлөх, санхүүжилт шаардлагатай байгаа компаниудад хөрөнгийн зах зээл дээрээс санхүүжилт татах боломжийн талаар зөвлөгөө өгөн ажиллаж байна


- a) Иргэдэд зориулсан цогц үйлчилгээ

- b) Аж ахуйн нэгжүүдэд зориулсан үйлчилгээ
- i. Тендер санал зарлах
 - ii. Компанийн хэлбэрийг өөрчлөх
 - iii. Хувьцаа эзэмшигчдийн хурал
 - iv. Санхүүжилт татах
 - v. Компанийн засаглалын зөвлөгөө зэрэг үйлчилгээнүүдийг харилцагч байгууллагуудад хүргэж байна.

d. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдаж авахад зуучлах үйлчилгээ: Манай компани 2017 оны 3-р сарын 22-ний өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос уг зөвшөөрлийг авч, харилцагч, хөрөнгө оруулагчдад гадаадын томоохон хөрөнгийн зах зээл дээрээс үнэт цаас худалдан авах, худалдах захиалгыг зуучлалын үйл ажиллагааг гүйцэтгэж байна.

6. Үнэт цаас гаргагчийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл:

- Компанийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл /2019.03.22-ний өдрөөр/:




7. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга:

№	Овог нэр	Албан тушаал	Боловсрол
1	Д.Даянбилгүүн	Гүйцэтгэх захирал	Дээд
2	Б.Лхагвадорж	Тэргүүн дэд захирал	Дээд
3	Н.Батгэрэл	Дэд захирал	Дээд
4	James Passin	ТУЗ-ийн гишүүн	Дээд
5	Д.Амгаланбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд
6	Hitoshi Tani	ТУЗ-ийн гишүүн	Дээд
7	Б.Энхбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд
8	Б.Амарсанаа	ТУЗ-ийн гишүүн	Дээд
9	Uluc Bingol	ТУЗ-ийн гишүүн	Дээд
10	Б.Тэмүүлэн	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Дээд
11	С.Пүрэвсүрэн	Дотоод албаны менежер	Дээд
12	Г.Гэрэлт-Од	Ерөнхий нягтлан бодогч	Дээд
13	Ш.Шинэбаяр	Хөрөнгө оруулалтын албаны менежер	Дээд
14	О.Уранбайгаль	Харилцагчийн албаны менежер	Дээд

8. Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчдийн мэдээлэл:

№	Овог нэр	Албан тушаал	/2019.03.22-ний өдрөөр/ Хувьцааны хувь
1	Д.Даянбилгүүн	Гүйцэтгэх захирал	18.89%
2	Тасган Инвест ХХК	-	12.10%
3	Монголиан Мастер Менежмент ХХК	-	7.94%
4	Impera Mongolia Holdings Ltd	-	5.68%
5	ХБНГУ-н хөрөнгө оруулагч	-	24.13%



ТАЙЛАНГИЙН ХОЁРДАХЬ ХЭСЭГ

Санхүүгийн тайлангийн үзүүлэлт:

1. Компанийн 2017, 2018, 2019 оны эхний хагас жилийн орлогын тайлангийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

Үзүүлэлт /мян.төг/	2017 он	2018 он	2019 он 1-р хагас
Борлуулалт	2,106,342.7	4,868,545.2	740,892.4
Борлуулалтын хөнгөлөлт	-	-	-
Цэвэр борлуулалт	2,106,342.7	4,868,545.2	740,892.4
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-	-
Үйл ажиллагааны зардал	(1,769,354.4)	(3,859,551.4)	(1,335,221.5)
Үйл ажиллагааны ашиг /алдагдал/	473,390.8	1,175,975.4	(594,329.1)
Үйл ажиллагааны бус зардал	(17,445.3)	(45,034.6)	(97,685.1)
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	1,178,508.3	1,691,567.6	(692,014.2)
Орлогын татварын зардал	(80,154.7)	(180,780.2)	(4,596.1)
Цэвэр ашиг /алдагдал/	1,098,353.5	1,510,787.3	(696,610.3)

*Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа явуулах этгээдэд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн загварын дагуу Компанийн 2017, 2018, 2019 оны 1-р хагас жилийн хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

Хөрөнгө, өр төлбөрийн үзүүлэлтүүд /мян. төг./	2017 он	2018 он	2019 он 1-р хагас
Эргэлтийн хөрөнгө	13,529,015.3	16,020,129.5	16,199,567.8
Эргэлтийн бус хөрөнгө	5,408,168	4,873,858.2	4,797,040.6
Нийт хөрөнгийн дүн	18,937,183.2	20,893,987.7	20,996,608.4
Богино хугацаат өр төлбөр	3,252,615.5	1,504,012.9	780,204.4
Урт хугацааны өр төлбөр	-	3,701,837.4	4,501,068.4
Эзэмшигчдийн өмчийн дүн	15,684,567.7	17,192,150.3	16,495,539.9
Өр төлбөр, эзэмшигчдийн өмчийн дүн	18,937,183.2	20,893,987.7	20,996,608.4

2. Компани нь 2019 оны 1-р хагас жилийн байдлаар 0.7 тэрбум төгрөгийн алдагдалтай байна. Мөн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс их байна.

3. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээр нь үнэт цаас эзэмшдэг талаарх мэдээлэл /2018.04.02-ний байдлаар/:

№	Овог, Нэр	Цалин урамшуулалын хэмжээ /жил/	Хандив тусламж	Бусад	Эзэмшиж буй хувьцааны тоо
1	Б.Лхагвадорж	6,000,000	-	-	3.59%
2	Д.Даянбилгүүн	6,000,000	-	-	18.89%
3	Н.Батгэрэл	6,000,000	-	-	2.54%
4	James Passin	6,000,000	-	-	-
5	Амгаланбаяр	6,000,000	-	-	2.50%
6	Hitoshi Tani	6,000,000	-	-	2.33%
7	Б.Энхбаяр	6,000,000	-	-	0.003%
8	Б.Амарсанаа	6,000,000	-	-	-
9	Philip Khoury	6,000,000	-	-	-

4. Ногдол ашгийн талаарх мэдээлэл:

“БиДиСЕК ҮЦК” ХК нь 2006 оноос хойш нийтдээ 6 удаа хувьцаа эзэмшигч нартаа ногдол ашиг тараасан ба 2013 онд нэгж хувьцаанд 11.78 төгрөг, 2012 онд нэгж хувьцаанд 60 төгрөг, 2010 онд нэгж хувьцаанд 50 төгрөг, 2008 онд нэгж хувьцаанд 5 төгрөг, 2007 онд нэгж хувьцаанд 30 төгрөг, 2006 онд нэгж хувьцаанд 3 төгрөгийг тус тус тараасан болно.

5. Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаарх мэдээлэл:

“БиДиСЕК ҮЦК” ХК нь 2019 онд “Компанийн тухай хууль”-ийн 87 зүйлд заасан их хэмжээний хэлцэл хийгээгүй болно. Мөн “Компанийн тухай хууль”-ийн 89 дүгээр зүйлд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй болно.

6. Үнэт цаас гаргагчийн ТУЗ, дэд хороодын үйл ажиллагааны тайлан:

Овог нэр	Эрхэлдэг ажил	Эзэмшсэн боловсрол мэргэжил	Эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь	Хараат бус гишүүн эсэх
1.Б.Лхагвадорж	ТУЗ-ийн дарга	Дээд, нефтийн инженер	3.59%	Хараат
2.Д.Даянбилгүүн	ТУЗ-ийн гишүүн	Дээд, Бизнесийн удирдлага	18.89%	Хараат
3.Н.Батгэрэл	ТУЗ-ийн гишүүн	Дээд, Гадаад харилцаа	2.54%	Хараат
4. James Passin	ТУЗ-ийн гишүүн	Дээд	-	Хараат
5. Uluc Bingol	ТУЗ-ийн гишүүн	Дээд	-	Хараат
6.Д.Амгаланбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд	2.50%	Хараат бус
7. Hitoshi Tani	ТУЗ-ийн гишүүн	Дээд	2.33%	Хараат бус
8.Б.Энхбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд	0.003%	Хараат бус
9.Б.Амарсанаа	ТУЗ-ийн гишүүн	Дээд	-	Хараат бус

Компани нь 2019 оны 04-р сарын 23-ны өдөр “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ыг зарлан хуралдуулж, ТУЗ-ын гишүүдийг дахин сонгосон бөгөөд 2019 оны 04-р сарын 24-ний өдөр ТУЗ-ийн хурлыг хуралдуулан, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар Б.Лхагвадоржийг томилж, ТУЗ-ийн дэргэдэх дэд хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх аудитын хороог Хитоши Тани, Жэймс Пассин, Д.Амгаланбаяр гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн

хараат бус гишүүн Хитоши Тани-г томилсон.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшуулалын хороог Н.Батгэрэл, Б.Амарсанаа, Д.Амгаланбаяр гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Н.Батгэрэл-г томилсон.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороог Д.Даянбилгүүн, Б.Энхбаяр, Улуч Бингол гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Д.Даянбилгүүн-г томилсон.

2019 онд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гарган баталж, 3 удаа ирц бүрдүүлэн хуралдаж ХЭХ-аас гаргасан тогтоол шийдвэрийн дагуу 13 асуудал хэлэлцэж нийт хэлэлцсэн асуудлаар 13 тогтоол баталж, гүйцэтгэлд хяналт тавьж дүгнэж ажилласан.

Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан:

а. Брокер, дилерийн үйл ажиллагаа:

2019 оны хагас жилийн байдлаар МХБ-ийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжаагаар 1.35 тэрбум төгрөг, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 4.02 тэрбум төгрөг, Засгийн газрын бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар 148.3 сая төгрөгийн үнийн дүн бүхий гүйлгээг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

“ҮЦТХТ” ХХК дээр тайлант хугацаанд 60,101 шинэ данс нээж, харилцагчийн тоогоо нэмэгдүүлсэн байна.

б. Андеррайтерийн үйл ажиллагаа

2.1. Андеррайтерийн үйл ажиллагааны хүрээнд:

БиДиСек ХК нь 2019 оны эхний хагас жилийн байдлаар нэг компанитай андеррайтерийн гэрээ байгуулан ажиллаж байгаа ба тухайн гэрээний хүрээнд үнэт цаас гаргагчийн хувьцааг Монголын Хөрөнгийн биржид бүртгүүлэх, хувьцааг олон нийтэд санал болгон арилжаалах үйл ажиллагааг гүйцэтгэхэд Андеррайтерын үйлчилгээ үзүүлж байна.

2.2. Компаниудтай хамтран ажиллах, харилцааг идэвхжүүлэх ажлын хүрээнд:

Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах сонирхол бүхий ХХК болон ХК-иудтай уулзалт зохион байгуулах, төслийг авч судлан хамтран ажиллах, мэргэжлийн гарын авлага гаргах, танилцуулах зэрэг ажиллагааг хэрэгжүүлж байна.

2013 онд эхэлсэн “Project hunting” буюу ТОП 150 компаниуд болон өсөн дэвжиж буй компаниудыг сонгон хөрөнгийн зах зээлд гарах боломжийн талаар танилцуулга хийх, холбогдох уулзалтуудыг зохион байгуулах зэрэг ажлыг тогтмол хийдэг. Мөн Монголын

Хөрөнгийн Бирж ТӨХК-д бүртгэлтэй ХК-иудад зөвлөх үйлчилгээ үзүүлэх, холбоотой гарын авлага болон бусад холбогдох судалгааг тус тус гарган ажиллаж байна.

Дээрхээс гадна компаниуд, хөрөнгө оруулагчидтай хамтын ажиллагааг эхлүүлэх, идэвхижүүлэх үүднээс гадаад, дотоодын томоохон чуулга уулзалтуудад оролцдог.

с. Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ

2019 оны хагас жилийн байдлаар байгууллагын зөвлөхийн үйл ажиллагааны хүрээнд дараах үйл ажиллагаагаа амжилттай явуулж нийт 5 компанитай гэрээ байгуулан ажиллав.

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурал зохион байгуулах - 6
- Сургалт - 5

Мөн оны хагас жилийн байдлаар нийтдээ 2 хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссоор ажилласан.

3.2. Судалгаа шинжилгээ

Бид өдөр тутмын болон долоо хоногийн арилжааны мэдээ мэдээллийг монгол болон англи хэлээр харилцагч нарт явуулж байна. Шинээр гарч буй судалгаанууд манай вэб сайт болон вэб пэйж-д нийтлэгдэж байна.

Мөн бид 2019 оноос 7 хоногийн тайланг гаргаж харилцагч нартаа хүргэж эхэлсэн.

d. Санхүүгийн тайлан /2019 оны 1-р хагас жил/

БиДиСЕК ҮЦК ХК нь 2019 оны 1-р хагас жилд нийт 740 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого олж 0.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан

Компаний балансийн нийт хөрөнгө 2019 оны 1-р хагас жилд 20.99 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.49 хувийн өсөлттэй байна.

ТАЙЛАНГИЙН ГУРАВДАХЬ ХЭСЭГ

Компани нь 2019 оны 4 сарын 23-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

- a. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах
- b. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
- c. Компани ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-н гаргасан шийдвэрийг танилцуулах
- d. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах
- e. Хөрвөх нөхцөлтэй санхүүжилт татах тухай
- f. ТУЗ-ийн 2019 оны төсөв батлах
- g. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Компани нь 2018 оны 4 сарын 23-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

- h. Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах, батлах
- i. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах
- j. Компани ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах
- k. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- l. ТУЗ-ийн 2018 оны төсөв батлах

Компани нь 2017 оны 4 сарын 26-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

- a. Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах
- b. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
- c. Компани ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-н гаргасан шийдвэрийг танилцуулах
- d. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- e. ТУЗ-ийн 2017 оны төсөв батлах
- f. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай
- g. Компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоог тогтоох тухай

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар
дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө
27/1, БиДиСЕК ҮЦК ХК

Утас: 7555 1919,
И-мэйл: info@bdsec.mn

